



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот


Тамга, тэмдэг шинээр хийлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 226 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын хүрээнд байгууллагын тамга, тэмдэг шинээр хийлгэх ажлыг зохион байгуулахыг Захиргааны хэлтэс (Х.Содномдэмбэрэл)-т үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 222.300 /хоёр зуун хорин хоёр мянга гурван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Өнөржаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Тамга, тэмдгийн хяналтын дугаар авах, захиалах, хийлгэх, хуучин тэмдгийг хураалгах ажлыг холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулахыг Захиргааны хэлтэс (Х.Содномдэмбэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500001



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2022 оны 02 сарын 08 өдрийн  
А/А дугаар тушаалын хавсралт



ТАМГА, ТЭМДЭГ ШИНЭЭР ХИЙЛГЭХ АЖЛЫН  
ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Тамга хийлгэх зардал	ш	1	105,150	105,150
2.	Тэмдэг хийлгэх зардал	ш	1	97,150	97,150
3.	Улсын тэмдэгтийн хураамж	ш	2	10,000	20,000
НИЙТ ДҮН:					222.300

-oo0oo-